



ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2015 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот

Ажлын хэсэг томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 2, Төрийн өмчийн хорооны 2015 оны 03 сарын 05-ны өдрийн 119 дүгээр тогтоол, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны 08 дугаарын 29-ний өдрийн 12 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй шуурхай үйлчилгээний "Терракан" маркийн автомашиныг төрийн өмчийн хорооны 119 дүгээр тогтоолын дагуу Тахарын ерөнхий газрын есдүгээр тойргийн тахарын албанд хүлээлгэн өгөх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн дарга: Ц.Мартгэрэл Удирдлага санхүүгийн албаны дарга

Гишүүд:	Б.Баярцэнгэл	Ахлах нягтлан бодогч
	Д.Булгамаа	Тооцооны нягтлан бодогч
	Л.Ганцэцэг	Нярав
	Х.Нандинтулга	Жолооч

2. Шуурхай үйлчилгээний автомашины хувийн хэрэгт сэргээн босголтын зардлыг хавсарган, автомашины эд ангийг нягтлан, биетээр нь хүлээлгэн өгөхийг ажлын хэсэг /Ц.Мартгэрэл/-т, автомашиныг хууль тогтоомжийн дагуу үндсэн хөрөнгөөс хасаж, санхүүгийн бүрдэл хийхийг ахлах нягтлан бодогч /Б.Баярцэнгэл/-д тус тус зөвшөөрсүгэй.

3. Шуурхай үйлчилгээний автомашиныг балансаас балансад шилжүүлж байгаатай холбогдуулан шинээр автомашин худалдан авах асуудлыг хууль, журмын дагуу төрийн өмчийн хороонд тавьж шийдвэрлүүлэхийг ажлын хэсэг /Ц.Мартгэрэл/-д даалгасугай.

4. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Удирдлага санхүүгийн алба /Ц.Мартгэрэл/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.ЦОГТБААТАР